


АНГИЙН АДМИН БУЮУ АНГИ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН АШИГЛАХ ТҮВШИН

ХҮСЭЛТ ИЛГЭЭХ ХЭСГИЙН ЗААВАР



Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчийн бүртгэлийг хийхийн тулд интернэтэд холбогдсон төхөөрөмжөөс дараах веб хөтчүүдийн аль нэгийг ашиглан <https://psod.maf.gov.mn> домэйн хаягаар хандана.




Анги, байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн нь өөрийн ашигладаг имэйл хаягаа харьяа командлалын хүний нөөцийн мэргэжилтэнд хэлж бүртгүүлнэ.



Бүртгүүлсэн имэйл хаягаа [“Имэйл баталгаажуулах”](#) дээр дарж гарч ирсэн цонхны [Имэйл хаяг](#) нүдэнд бичин [“Имэйл баталгаажуулах холбоосыг илгээх”](#) товчийг дарснаар 6 оронтой код таны имэйл хаягт ирнэ.




Имэйл хаягт ирсэн 6 оронтой кодыг [“Имэйл баталгаажуулах холбоосыг илгээх”](#) товчийг дарснаар гарч ирэх цонхонд оруулж [Баталгаажуулах](#) товчийг дарна.




[Баталгаажуулах](#) товчийг дарснаар таны имэйл хаяг баталгаажиж тухайн системтэй ажиллах эрхтэй болно. Имэйл амжилттай баталгаажсаны дараа тухайн системд нэвтрэх өөрийн нууц үгийг заавал үүсгэнэ.


Баталгаажуулах товчийг дарснаар таны имэйл амжилттай баталгаажиж [Нууц үг тохируулах](#) товчийг дарснаар нууц үг шинэчлэх хэсэгт шилжинэ.




Өөрийн ашиглах нууц үгээ оруулаад [Шинэчлэх](#) товчийг дарснаар Энхийг сахиулах сонгон шалгаруулалтын системтэй ажиллах эрхтэй болно.



[Нэвтрэх хэсэг рүү шилжих](#) товчийг дарж нэвтрэх хэсэгт шилжинэ.



Нэвтрэх хэсэгт өөрийн баталгаажуулсан имэйл хаяг болон нууц үгээ оруулж **НЭВТРЭХ** товчийг дарснаар Бүртгэлийн үндсэн цонхонд шилжинэ.



ЭДЦХАХ

Ажиллагааны нэр: Сонгоно уу | Ээлж: Сонгоно уу

а/д Амарбаясгалан

а/д Амарбаясгалан

Та Энхийг дэмжих ажиллагааны веб програмд амжилттай нэвтрлээ.

Хэрэглэгч бүртгэх:
Алхам 1. Та **ХЭРЭГЛЭГЧ** цэсийн **Хэрэглэгч бүртгэх** туслах цэс дээр дарж өөрийн харьяа анги/нэгтгэл/, салбарын ЦАХ-ийг бүртгэнэ.


Хүсэлт илгээх:
Алхам 1. Та **ҮНДСЭН** цэсийн **Хүсэлт** илгээх туслах цэс дээр дарж Асуумж бөглөнө.
Алхам 2. Асуумжийг үнэн зөв бөглөсний дараа Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлт илгээнэ.
Алхам 3. ЭДА-нд үүрэг гүйцэтгэх хүсэлт илгээсний дараа **Бичиг баримтын бүрдэл** цэс дээр дарж бичиг баримтуудаа оруулна.
Алхам 4. Бүрдүүлэх ёстой бүх бичиг баримтаа оруулсан бол **Оролцооны байдал** туслах цэс дээр дарж оролцооны байдлаа харна.
Алхам 5. Та Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхтэй холбоотой санал, гомдолтой бол **Санал гомдол** туслах цэс дээр дарж илгээнэ.
Алхам 6. Та дараагийн жилүүдэд Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтэй бол **Хүсэлт илгээх он** туслах цэс дээр дарж хүсэлт илгээнэ.

Санамж: Асуумжийн мэдээллийг алдаатай илгээсэн тохиолдолд засах боломжгүй!

Зөвсэгт хүчний Програмын ханганжийн төвд хөгжүүлэв © Бүх эрх хуулиар хангаалагдсан 2023

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ ХЭСГИЙН ЗААВАР

Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын системд анги, байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн өөрийн эрхээр Нэвтэрч орсны дараа **ҮНДСЭН**, **ХҮСЭЛТ ИЛГЭЭХ**, **ЗАРЛАЛ**, **ХЭРЭГЛЭГЧ** гэсэн 4 үндсэн цэс харагдана.



Анги, байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн **ХЭРЭГЛЭГЧ** цэсийн **Хэрэглэгч бүртгэх** дэд цэсийг дарж энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн албан хаагчдын бүртгэлийг хийх ба цэргийн албан хаагч нь тухайн анги, байгууллагад ажилладаг нь үнэн л бол өөр **ЯМАР Ч ШАЛГУУР ТАВИЛГУЙ** цэргийн албан хаагчийн имэйл бусад мэдээллийг оруулах үүрэгтэй.

ХҮСЭЛТ ИЛГЭЭХ цэсийг дарж тухайн хүний нөөцийн мэргэжилтэн өөрөө ЭДА-ны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлж болно. Энэ нь хувь хүн хүсэлтээ илгээхтэй адилхан үүрэгтэй.

Хэрэглэгч бүртгэхийн тулд **+НЭМЭХ** товчийг дарж гарч ирэх цонхонд ЦАХ-ийн хувийн мэдээллийг хүснэгтийн дагуу үнэн зөв оруулаад **Нэмэх** товчийг дарж бүртгэл хийнэ.

№	Цээж зураг	Цол	Овог	Нэр	РД	Нас	Хүйс	Гадаад паспорт	Гадаад паспортын дуусах хугацаа	Утасны дугаар	Цахим хаяг
---	------------	-----	------	-----	----	-----	------	----------------	---------------------------------	---------------	------------

Заавал бөглөх ёстой талбар

*Командлал: ЭХЖШ *Анги сонгох: ЭХ-ний 189

*Бүрэлдэхүүн: Сонгоно уу *Цолны төрөл: Сонгоно уу

*Цол: Сонгоно уу *Хүйс: Сонгоно уу

*Овог: *Нэр:

*Регистрийн дугаар: *Эрх: Сонгоно уу *Нас:

*Албан тушаал:

*Утасны дугаар: *Цахим хаяг:

Гадаад паспорт: Дуусах хугацаа: mm/dd/yyyy

Choose File No file chosen

Цээж зураг нь албаны хувцастай, одоо байгаа цол, нэр, ромбо харагдахуйц 3x4 жэмжтэй байх шаардлагатай.

Нэмэх Хаах

Танд амжилт хүсье
Холбоо барих утас: 3888,92113255